

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

**МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН ОЮУТНУУДАД ЗОРИУЛАВ**

2011 он

АГУУЛГА

Өмнөх үг	3
Оршил	5

Нэгдүгээр бүлэг:

Өөрийгөө танин мэдэх	7
----------------------------	---

Хоёрдугаар бүлэг:

Миний өнгөлөн сайжруулах давуу талууд	17
---	----

Гуравдугаар бүлэг:

Ажил мэргэжил, түүний онцлог	24
Хоол, хүнсний үйлдвэрлэлийн технологич	28
Цахилгаанчин /угсралтын ба тоног төхөөрөмжийн/	31
Хүнд механизмын оператор	34
Эрчимжсэн мал аж ахуйн фермер	37

Дөрөвдүгээр бүлэг:

Хөдөлмөр эрхлэлт ба миний сонголт	40
Өөрийгөө хэрхэн танилцуулах баримт бичиг бэлтгэх	44

Тавдугаар бүлэг:

Хөдөлмөрлөх эрх, үүрэг, хөдөлмөрийн харилцааны тухай	52
--	----

Боловсруулсан: Т.Эрдэнэбилэг

Хянасан: Э.Ундрах

ӨМНӨХ ҮГ

Монголын Мянганы сорилтын сангийн Мэргэжлийн боловсрол сургалтын төслийн хүрээнд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тухай гарын авлага бэлтгэн гаргаж Та бүхэнд толилуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл нь АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилготой хэрэгжүүлж буй хөтөлбөрийн нэгээхэн хэсэг бөгөөд эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог дэмжсэн шинэ бүтцийг бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангасан, чанартай сургалтын тогтолцоог хөгжүүлэх үндсэн зорилготой. Уг зорилгод хүрэхийн тулд төсөл маань төр, хувийн хэвшлийн оролцоог хангах, ур чадварын стандарт тогтоох, чадамжид суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх, ажил, мэргэжлээрээ өсөх талаар зөвлөгөө өгөх зөвлөх үйлчилгээг бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн материаллаг орчинг сайжруулахад чиглэсэн харилцан уялдаа, холбоо бүхий цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа билээ.

Төслийн хүрээнд МБС-ын үр нөлөө, ач холбогдлыг тодотгосон мэдээлэл, сурталчилгааны ажлыг олон нийтийн дунд зохион байгуулж, сургалтын байгууллага, суралцагч буюу зорилтод бүлгүүдийг онцгойлон анхаарсан төдийгүй эцэг эхчүүд, нийт иргэдэд боловсрол олгох танин мэдэхүйн олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаагийн нэг жишээ бол энэхүү гарын авлага юм. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцаж буй болон суралцахыг хүсч байгаа оюутан залууст зориулж анхны ажлын байраа олоход нь туслах, тэдэнд ажил мэргэжлийн тухай зөв хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөрийн харилцаанд ороход нь дэм болох зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэлээ.

Түүнчлэн, төслийн үйл ажиллагааны нэгээхэн хэсэг нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг Монголд бий болгоход чиглэж байгаа юм. Ажил хайж байгаа иргэд, төгсөх ангийн оюутан сурагчид, сургуулиас завсардагсад, сургууль төгсөөд ажилгүй байгаа залуус, мөрөөдлийн ажлаа хайж байгаа хэн бүхэнд хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээл дээр шинээр бий болж байгаа ажлын байр, мэргэжлийн тухай танилцуулах замаар боловсрол, сургалт, ажил хөдөлмөрийн сонголт хийх, карьерээ сайжруулахад нь туслах ажил, мэргэжлийн зөвлөхүүдийг сургах ажлыг хийх төлөвлөгөөтэй байгаа билээ.

Энэхүү гарын авлагыг бэлтгэн боловсруулах ажлыг голлон гүйцэтгэсэн ММСС-гийн МБС-ын төслийн олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэрээт байгууллага болох Брэйктрүү ПР-ын компани болон хамтран ажилласан бусад бүх байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

Эрхэм залуус Та нарын ажил хөдөлмөрийн гарааны хөтөч болгон энэхүү номыг хүргэж байгаад бид туйлын их баяртай байна.

Ц.Ундрах



ММСС-гийн МБС-ын төслийн дэд захирал

ОРШИЛ

Өнөөдөр Монгол орны маань ирээдүй, бүтээн байгуулалтын эзэд залуучуудад ажил хөдөлмөрийн ертөнцөд орж хөдөлмөрийн гараагаа эхлэхэд нь тус дэм, заавар зөвлөмж болохуйц гарын авлага, ном нэн ховор. Иймд Монголын Мянганы сорилтын сангийн Мэргэжлийн боловсрол сургалтын төслөөс та бүхэнд хүргэж буй энэхүү гарын авлага маань залуучууд хүсэл мөрөөдөл дээрээ суурилан хэрхэн авьяас билэг, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд тус болно хэмээн итгэж байна.

Манай зарим эцэг эх, багш нар хүүхэд, залуучуудад өрөөсгөл мэдээлэл өгөх нь олонтаа. “Эрэлт багатай мэргэжлээр яах юм бэ, төгсөөд юу хийх вэ?, тэрний оронд хуульч, эдийн засагч болсон нь дээр” гэхчилэн хүүхдийнхээ хүсэл сонирхлын дагуу биш сургуульд оруулснаар хүүхэд өөрийн дур сонирхсон мэргэжлийн чиглэлээр сурч чадахгүйд хүрдэг. Үүний үр дүн алхам тутам мэдрэгдэнэ. Мэдээж тухайн хүүхэд өөрөө сонирхоогүй учраас идэвх чармайлт муутай сурч, мэдлэг боловсрол, ур чадвар муутай мэргэжилтэн болж төгсөнө. Ажил олгогч нар ур чадвар муутай мэргэжилтнүүдийг голж шилсээр байна. Энэ бол манай Монголд нийтлэг ажиглагддаг харуусалтай нэгэн дүр зураг.

Тэгвэл энэхүү дүр төрхөөс бид яаж гарах вэ? гэвэл хүүхэд залуучуудаа бага балчраас нь эхлэн өөрөө өөрийнхөө дотоод ертөнцийг нээж өөрийгөө танин мэдэхэд нь чиглүүлэн туслах, мөн тэднийг өсөх наснаас нь ажиглан юунд дур сонирхолтой, юунд авьяастайг нь мэдэрч тэр чиглэлээр нь түлхүү хөгжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байгаа юм. Ингэж гэмээ нь хүүхэд залуучууд маань өөртөө итгэлтэй болно. Аль нэг зүйлд арай илүү авьяастайгаа мэдэрсэн өөртөө итгэлтэй хүүхэд хөндлөнгийн хэн нэгнээр хэлүүлэлгүйгээр өөрийгөө хөгжүүлэхэд анхааран түүндээ цаг заваа зарцуулж эхэлдэг. Ажил мэргэжлийн аль нэг

чиглэлд дур сонирхолтой болж тэр талынхаа авьяас билгийг тодорхой хэмжээнд хөгжүүлсэн хүүхэд дунд сургууль төгсөөд дараагийн шатны сургуульд элсэн орохдоо мэргэжлээ зөв сонгоно. Сонирхсон мэргэжлийнхээ дагуу сургуульд орсон оюутан мэдлэг, боловсролыг сайн эзэмшдэг. Ингэснээр тэр боловсрол, мэдлэгтэй чадварлаг мэргэжилтэн болж төгсөнө. Мэдлэг боловсрол, авьяас чадвартай шижигнэсэн залуу мэргэжилтнээс татгалзах ажил олгогч гарна гэж үү? Тэд булаацалдах шахам ажилд авна.

Ийнхүү өгүүлэхийн гол утга нь ерөнхийдөө “хүн мэргэжлийг голдоггүй харин мэргэжил хүнийг голдог” гэсэн ганцхан утганд ирж зангидагдаж байгаа хэрэг. Тэгвэл мэргэжилдээ гологдолгүй ирээдүйдээ яаж итгэлтэй алхаж гэрэлтэй сайхан амьдрах вэ? гэдэгт манай энэхүү гарын авлага олон залуучуудыг уриалан дуудна гэдэгт итгэж байна. Энэхүү гарын авлагаар хүн хэрхэн өөрийгөө танин мэдэх тухай аргачлал, өөрийгөө танин мэдсэнээр өөрийн орхиж болох зуршлыг нээхийн зэрэгцээ, эерэг өөрчлөлт, хандлагыг өөртөө дадуулах дасгалууд, өөрийгөө хөгжүүлэх, ажил мэргэжлээ хэрхэн сонгох мэдээллийг агуулж байгаагийн зэрэгцээ ажлын талбарт тулгардаг бэрхшээлтэй асуудлуудыг хэрхэн шийдэж болох тухай зөвлөмжийг хүргүүлж байна.

Залуучуудаас гадна тэдний багш, эцэг эх, ажил олгогчид гээд нийгмийн олон салбар хүрээний хүмүүсийн хэрэгцээнд нийцэх юм.

Эцэст нь энэхүү гарын авлага маань өөрийгөө хөгжүүлэхийн гэрэл гэгээгээр гийж, сайн сайхан ажил амьдрал, амжилт бүтээлийн төлөө дотроосоо бадарч яваа хэн бүхний гарын үзүүрт ойр байж хүслийн замд нь жолоо болохыг бэлгэдэн хүснэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ӨӨРИЙГӨӨ ТАНИН МЭДЭХ

Өөрийгөө танин мэднэ гэдэг нь гадна өнгөнд харагдах бие галбир, намба төрхөөс эхлээд дотоод өнгөнд байх зан ааш, авъяас,ур чадварууд, санаа бодол зэрэг өөрийн гэх бүхий л зүйлсээ үнэн зөвөөр мэдрэхийг хэлнэ. Аливаа хүн өөрийнхөө мөн чанарыг хэдий чинээ танин мэдэж чадна төдий чинээ өсөж хөгжиж байдаг байна. Өөрийнхөө мөн чанарыг үнэн зөвөөр танин мэдэж чадаагүй хүн өөрийнхөө сул тал, муу зуршлыг олж хардаггүй. Тиймээс дорой байдал, муу дадлаасаа салж өөртөө эрч хүч, урам зоригийг авч чаддаггүй байна. Өөрөөр хэлбэл “энэ хүн намайг муухай ааштай, харилцааны соёлгүй гэлээ. Би ямар тийм юм уу?” гэж өөрийгөө өмөөрч бодохоосоо өмнө “яагаад энэ хүн намайг ингэж бодов? Би сая ямар ааш гаргав?” гэж өөртөө дүгнэлт хийж “аа миний тийм ааш зан хүнд таалагддаггүй юм байна” хэмээн ойлгож чадаж байгаа хүнд түүнийгээ засах тийм ч хэцүү биш. Учир нь тэр өөрийгөө таньж, ойлгож, мэдэрч чадаж байна. Үүнийг л өөрийнхөө мөн чанарыг танин мэдэх гээд байгаа хэрэг шүү дээ.

Ийнхүү өөрийгөө үнэн зөвөөр танин мэдсэн хүний өмнө хөгжин цэцэглэх, сурч боловсрохын үүд хаалга үргэлж нээлттэй байдаг. Та өөрийгөө хэр чинээгээр танин мэдэж, төдий хэмжээгээр хөгжүүлж чадаж байна вэ гэдгээс чинь Монгол улсын ирээдүйн хөгжлийн асуудал шалтгаална гэдгийг санахад илүүдэхгүй.

Залуучууд бидний орчинд жишээ нь сургуульд, зарим тохиолдолд эцэг эхийн найз, үе тэнгийнхэн, ер нь их олон хүн өөрийгөө танилцуулна уу гэсэн сонирхолтой асуулт бидэнд тавьдаг. Энэ асуултад хэрхэн оновчтой, товч, тодорхой хариулах вэ? Насанд хүрсэн бидэнд яагаад энэ асуулт чухал байдаг вэ?

“Би” өөрийгөө хэний хэн болох, ямар мэдлэг, боловсрол эзэмшсэн зэргийг бол мэднэ ээ.

ХАРИН?

- Би ямар хүсэл сонирхол, мөрөөдөл, авьяас, ур чадвартай вэ? Эдгээрийг сайжруулан хөгжүүлж “би” ямар болж хэн шиг юу бүтээх билээ? гэсэн гайхамшигтай асуултаудад та энэ бүлгийг уншнаар хариулт өгөхөд бэлэн болно.

Би ямар хүсэл сонирхол, авьяас, ур чадвартай вэ? Түүнийгээ сайжруулан хөгжүүлэх ямар боломж надад байгаа билээ? гэдгийг үргэлж эрэлхийлж байдаг хүний зорилго аяндаа тодорхой болдог. Зорилго чиглэл тодорхой байна гэдэг бол амжилт бүтээл, алдар хүндийн үндэс болж өгдөг. Ямар ч зорилгогүйгээр хөдөлмөрлөөд амжилтанд хүрсэн хүн гэж нэг ч үгүйг анхаараарай залуучуудаа. Бид бүгдийн хүндлэн дээдэлдэг урлаг соёлын алдартнууд болон шилдэг улс төрчдийн тухай бичсэн ном зохиолыг уншаарай. Тэд бүгд өөрсдийнхөө өмнө маш тодорхой зорилго тавьж түүнийхээ төлөө нөр хичээнгүйгээр хөдөлмөрлөсөн байдаг. Жишээ нь: АНУ-ын ерөнхийлөгч асан Билл Клинтон аравдугаар ангид байхдаа тэмдэглэлийнхээ дэвтрийн эхний хуудсанд “Би АНУ-ын ерөнхийлөгч болно” гэж бичсэн байснаас үзэхэд тэр хүн хүүхэд байхаасаа л өөрийнхөө өмнө ямар том зорилго тавьж түүнийхээ төлөө уйгагүй хөдөлмөрлөн амжилтанд хүрч вэ гэдэг нь ойлгогдоно.

Ийнхүү та өөрийгөө таниж мэдсэнээр ирээдүйдээ тэмүүлэх зорилгоо илүү тодорхой болгоно. Нэгэнтээ таны зорилго тодорхой байгаа учир та ажил хөдөлмөрийн ертөнцөд өөрийгөө бэлтгэхийн тулд өөрийгөө дайчлан сурч хөдөлмөрлөж эхлэх болно. Учир нь таны хүсэл сонирхол, авьяас билэг, ур чадварууд нь хичээл зүтгэл, боловсрол мэдлэг, сургалт судалгаагаар

улам өнгө орон гялалзана. Өөрөөр хэлэх юм бол та хэдий чинээ боловсрол мэдлэг, авьяас билгээ хөгжүүлж чадна тэр хэмжээгээр ажил, хөдөлмөрийг удирдаж чадна гэсэн үг юм. Эдгээрийг сайтар тунгаан бодож өөрөө өөртэйгөө хичээнгүй ажиллаж чадсан хүн л сая хөдөлмөрийн ертөнцөд өөрийн гэсэн “би”-г бий болгож өөрийгөө тунхаглан зарладаг билээ.

Өөрийн сонирхол, авьяас, ур чадварыг тодорхойлох дараах асуултаудад хариулна уу

Миний сонирхол	Миний авьяас, чадамж	Миний ур чадварууд
Би юу хийх дуртай вэ?	Миний хамгийн хурдан хийж чаддаг зүйлс, үйлдэл юу билээ?	Би дунд, мэргэжлийн боловсролын сургууль, курст юуг сонирхон, ямар сурлаа?
Би юуны тухай уншиж, судлах дуртай вэ?		
Би чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ?	Би тоо бодох, бичиж туурвих, машин механизм засч сэлбэх, загвар зохион бүтээх, дуу дуулж бүжиглэх, дуртай бас хурдан сурдаг өөр юу байж болох вэ?	Би бусад хүмүүс болон ажлаас юуг хэрхэн хийж сурсан бэ?
Ямар ажил, юу надад аз жаргал, баяр бэлэглэж, намайг бас хөгжилтэй болгодог вэ?		
Хэрэв надад ийм ажил, үүрэг даалгавал би яаж хийж гүйцэтгэх вэ?	Би ямар авьяастай билээ?	Би ямар техник хэрэгсэл ажиллуулж чадах вэ?
		Би ямар курс, дамжаа, дугуйланд хичээллэсэн билээ?

Жишээ

Би 2-3 жилийн дараа бялуу хийдэг тасаг нээн ажиллуулна. Учир нь миний ээж нарийн боовчин мэргэжилтэй. Манай гэр бүлийн ярианы нэгэн гол сэдэв бол энэхүү нарийн боов, жигнэмэг, бялуу буюу хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүнийг бүтээх уран сэтгэмжийн тухай байдаг. Бид бялуу, жигнэмэг зэргийн амт шимт, өнгө үзэмж, чанар чансаа бол тухайн ажилтны ур чадвар, уран сайхны өндөр мэдрэмж учраас урлагийн бүтээл гэж үздэг. Бас эрүүл зөв хооллох хэрэгцээг хангах бүтээгдэхүүн гэж үзэж, харилцан ярилцдаг. Энэ нь миний хүсэл сонирхол, авьяасаа хөгжүүлэхийн гол үндэс буюу зорилго минь болсон юм. Дунд сургуульд сурч байхдаа мэргэжлээ сонгон төрөл бүрийн нарийн боов, бялууг хийх жор, хийх арга болон түүний талаарх мэдээллүүдийг цуглуулж эхэлсэн. Тийм ч учраас олны танил тогооч, нарийн боов хийдэг хүмүүстэй уулзаж, өдөрлөг, үзэсгэлэн яармагийн үеэр мэдээлэл, туршлага солилцон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сурч талх нарийн боовчны мэргэжил эзэмшсэн юм. Мөн хүмүүс болон эд материалтай харилцах, аливаад бүтээлч хандах, манлайлах ур чадваруудаа хөгжүүлсэн. Оюутан байх явцдаа танилцах үйлдвэрлэлийн дадлагаа “Жүр үр” бялуу үйлдвэрлэлийн компанид хийсэн бөгөөд дадлагын хугацаанд шинэ техник технологитой харилцах, тэдгээрийг ажиллуулахад мэргэшсэн. Талх бялууг шарах зуухны сонихон үнэр, содон сайхан дуу чимээ нь хүртэл миний сэтгэлийг татаж энэ чиглэлээр ажиллах хүсэл сонирхлыг минь нэмэгдүүлж байдаг юм.

Дээрхи жишээнд өгүүлж буй охины адил бид ч бас өөрийн хүсэл сонирхол, ур чадвар, авьяасаа хэрхэн хөгжүүлж зорилго чиглэлээ ажил хөдөлмөртэй холбох арга замуудыг энэхүү гарын авлагаас судалж мэдэх болно.

Тиймээс та өнөөдрөөс эхлэн өөрийгөө өөрчилж эхэл. Өөрийгөө удирдан жолоод. Яаж хөдөлмөрлөвөл бусад хүмүүсийн амжилтанд хүрсэн замналаас илүү хурдацтайгаар амжилтанд хүрч болох арга замыг хай. Сонирхож буй салбарынхаа чиглэлээр судалгаа хийж түүндээ тулгуурлан ажлын төлөвлөгөө гарга. Энэ явцад танд ямар нэгэн бэрхшээл тулгарч болзошгүй. Тэрхүү бэрхшээл саадыг л даван туулж чадвал та өөрийнхөө өмнө тавьсан зорилгодоо хүрлээ гэсэн үг. Нэгэн бодлын тун хялбар байгаа биз. Ер нь хүний амьдралын гол утга учир бол амьдралынхаа зорилгыг тодорхойлох явдал юм. Өөрөөр хэлбэл та юуны тулд амьдраад байгаагаа л ойлгох хэрэгтэй. Ямарваа хүнийг үнэлэх шалгуурын чухал хэсэг нь түүний амьдралын зорилго байдаг юм шүү.

Хүний хүсэл мөрөөдөл бодит амьдралтай зөрчилдөх явдал их байдаг. Үүнээс болж хүсэл тэмүүлэл сулрах, амьдралд итгэх итгэл алдрах, зориг шантрах явдал бишгүйдээ л гарна. Гэвч түүнийг даван туулах арга зам нь маш хялбар та өөрийгөө хөгжүүл, дасгалжуулж, зоригжуул ингээд л гүйцээ. Тэгээд би өөрийгөө яаж хөгжүүлж, яаж дасгалжуулах вэ? гэж та асуух нь магад. Тэгвэл танд дараахь хэдэн зөвлөмж буюу дасгалыг санал болгож байна.

1. Зохицон дасах.

Тогтсон горим, өдрийн дэглэм зэрэгт өөрийгөө зохицуулан өөрчлөх боломжтой үйлдлүүд юм. Жишээ нь өөрийн сонирхдог ном унших, биеийн тамир, хоол, бүжиг, оёдол, бялдаржуулах гэх мэт хичээл сургуулилт, дасгалаа хийж гүйцэтгэх тодорхой цаг гарган өдрийн дэглэм зохиох. Энэ нь нямбай, цаг баримталдаг, үүргээ ухамсарлан биелүүлдэг, сахилга дэг журамтай байх болон тогтсон цагт унтаж, сэрж, цагаа зөв хуваарилан өөрийгөө хөгжүүлэх дасгал болно. Үүнийг дагаж мөрдснөөр танд олон зэрэг өөрчлөлтүүд мэдрэгдэх болно.

2. Дуурайх.

Үйл ажиллагаагаараа болон зориудын дасгал сургуулилтаар хүч чадал, авьяас, оюун ухаанаа төлөвлөгөө, зорилготойгоор эрчимжүүлэн хурдасгаж хөгжүүлэх арга.

3. Өөрийгөө хөгжүүлэх.

Үйл ажиллагаагаараа болон зориудын дасгал сургуулилтаар хүч чадал, авьяас, оюун ухаанаа төлөвлөгөө, зорилготойгоор эрчимжүүлэн хурдасгаж хөгжүүлэх арга .

4. Өөрийгөө судал

Өөрийн зан үйл, сонирхол, хөгжил, мэдлэг боловсрол, ур чадваруудаа олж харвал өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө мөн хөгжүүлэх хоёр үйл ажиллагааг хамтад нь эхэлж үр дүнд түргэн хүрэх боломжтой. Өөрийн тухай бодол төсөөлөл нь өөрийн сайн, сул талуудаа олж харах, зорилго, зорилтоо тодорхойлох, төлөвлөлт хийж хөгжих суурь болно.

Хэдийгээр миний өнөөдрийн нөхцөл байдал ийм байгаа ч гэсэн “би заавал чадах ёстой, би заавал хийх ёстой” гэсэн зориг эрмэлзлэлээр дүүрэн бай. Ингээд танд агуулга, үйл ажиллагаа хоёроор өөрийгөө илэрхийлэх боломж олгоё.



Жишээ

Агуулга	Үйл ажиллагаа	Тайлбар
Улс төр, шинжлэх ухааны чиглэлээр өөрийгөө боловсруулах	Мэдээлэл цуглуулан тэдгээртэй танилцах, жагсаалт гарган ангилж чухал сэдвүүдээр мэдээллийн сан үүсгэх	Мэдлэг нь мэдээллээс үүсч бий болно. Иймд бид мэдээллээ зорилго, чиглэлтэй эмхтгэн цуглуулах хэрэгтэй
	Хэвлэл мэдээлэл, ном сонин унших	
	Улс төр, нийгмийн зүтгэлтнүүдтэй хийж буй уулзалт ярилцлагад оролцох	Бусдын сайн туршлага бидэнд илүү үр дүнд хүрэхэд тусална.
	Хууль дүрэм журмуудтай танилцах, судлах	Хүн, нийгмийн нийтлэг ёс зүйд суралцана.
	Судалгааны байгууллагуудын тайлан илтгэлийг унших, цуглуулах	Нийгэмд тулгамдсан болон шийдэж буй арга замуудыг судалж мэднэ.
Ерөнхий соёл эзэмших	Гоо зүйн мэдлэг мэдээллээ байнга нэмэгдүүлж байх	Гоо зүй энгийн үйлдэл, сэтгэлгээнээс эхэлнэ. Жишээ нь хувцасаа өнгө тохируулан өмсөх, гэр, албан тасалгааны тавилга сэлтийн байрлал, шийдэл
	Ном унших	Ном бол бидний эх дэлхий, хүн, нийгмээ харах цонх болно.
	Театр, үзвэр үйлчилгээ, кино, дуурь, балет үзэх	Уран сайхны мэдрэмж илүү өргөн болж өөрийгөө өөр өнцгөөс харах болно.
	Сонирхолтой хүмүүстэй уулзаж ярилцах	
	Хувцасны загвар сонирхон судлах	
	Урлаг, уран сайхны тоглолт, бүжиг дууг сонирхон судалж хичээллэх	
	Ургамал, цэцэг, ногоо тарьж ургуулах	Байгал, амьтан, орчин тойрноо хамгаалж, хайрлах мэдлэгтэй болно

Агуулга	Үйл ажиллагаа	Тайлбар
Ёс суртахууны хөгжил	Ардын, сонгодог уран зохиол уншин тэмдэглэл хөтлөх, цээжлэх	Эерэг хандлага, өөрчлөлтийг удирдана.
	Байнга уншдаг ширээний номоо сонгон уншиж тэднээс үлгэр дууриал, эрч хүч мэдрэх	Орчин, нийгэмдээ бүтээлч хандах шинэлэг, манлай лах арга замуудыг бий болгоно
	Оюун ухааны дасгал, бодлого бодох	Өөрийн зан байдалд хяналт тавьж бие даасан байдал, өөртөө итгэх итгэл нэмэгдэн дайчин, шаргуу хөдөлмөрч зан төлөвшинө.
	Үзвэр үйлчилгээ, орчин үеийн урлагийн бүтээлүүдтэй танилцан хүмүүс, нийгмийн хэв маяг, хандлагыг мэдрэх	
Бие бялдрын хөгжил	Спортоор хичээллэх	Эрүүл биед саруул ухаан оршино
	Бассейнд хичээллэх	
	Хөгжих	
	Бүжиг бүжих	
	Явган алхах	

5. Өөртэйгээ ажиллах төлөвлөгөө боловсруулах

Төлөвлөгөө гэж юу вэ? Аливаа үйлдэл, үйл ажиллагаа нь зохион байгуулалт, дараалал, цаг хугацаа, оролцоо, үр дүнг шаарддаг. Бид нэр алдартай хүмүүсийн өдрийн тэмдэглэл, зорилгоо тодорхойлсон зэргээс олон сайн жишээ мэддэг.

Төлөвлөгөө боловсруулахын тулд яах ёстой вэ? Эхлээд төлөвлөлт хэрхэн хийхийг мэдье.

Эхний алхам. Хийх ажлаа өдөр бүр төлөвлө, бод, дараа өдрийнхийг урьд орой нь бодож боловсруул. Мөн урьд өдөр нь бичиж төлөвлөсөн ажлуудаа биелүүлсэн эсэх, хэрхэн хийж гүйцэтгэсэнээ дүгнэн цэгнэ, түүний учир шалтгаан болоод үр дүнгийн талаар товч бич.

Хоёрдугаар алхам. Өдөр тутмын төлөвлөгөө боловсруулсны дараа зорилгоо тодорхойлон долоо хоногийн төлөвлөгөө бодож боловсруул. Үүнд ном унших, товч дүгнэлтээ бичих, уралдаан тэмцээнд бэлтгэж оролцох, үзвэр үйлчилгээ үзэх, спортоор хичээллэх, усанд сэлэх гэх мэтээр баяжуулан өөртөө сонирхолтой, өөрийн хийж бүтээхийг зорьж байгаа тодорхой ажлууд болон амралт чөлөөт цагаа ч орхилгүйгээр бүгдийг нь жагсаан тодорхой өдөрт хуваарилан төлөвлө. Эдгээрийг биелүүлэхийн тулд ямар цаг хугацаа шаардагдах, ямар нөөц бололцоог ашиглах тэр ч бүү хэл өөрөөсөө ямар хэмжээний эрч хүч зарцуулахаа үнэн зөв тооцоолж бодох хэрэгтэй болно. Ингэсний эцэст таны өмнө хөврөх нэг өдөр, долоо хоног, сар, улирал, он жилүүд улам утга учиртай болж хийж бүтээсэн бүхнийхээ үр шимийг хүртэн амжилт алдрын зэрэгт хүрнэ. Таны ажил үйлс бүхэн бүтэмжтэй байж аз жаргалаар бялхах болно.

Нийтлэг дараалал.

- ◆ Өдрийн дэглэм тогтоож, байнга түүнийгээ мөрдөх
- ◆ Хичээл, сургуульдаа очихдоо бэлтгэлээ байнга хангасан байх, багшийн заасан хичээлийг баяжуулан, холбогдох баримт судалгааг цуглуулсан байх
- ◆ Эхэлсэн ажлаа дуусгах
- ◆ Ажил бүрийг чанар, үр дүнтэй хийж гүйцэтгэх
- ◆ Биеэ, өөрийгөө эзэмдэж, бодол санаандаа хяналт тавьж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлж зорилго тэмүүлэлтэй болох хэрэгтэй.

Шигтгээ

Та хөгжилтэй эерэг сэтгэлгээтэй байхын тулд дараахь зарчмуудыг баримтлаарай. Үүнд:

- Өөртөө итгэ
- Үйлдэл, үйл ажиллагаагаа бодож эргэцүүлэн, аливаа зүйлд тайван олон талаас нь ханд бас харилцан ярилц
- Цаг хугацаа, үйл ажиллагаагаа зөв хуваарилан хүч чадлаа нэмэгдүүлэн тогтворжуулЧадна, сурна, хийнэ бүтээнэ гэсэн хүсэл сэтгэлийг байнга давтан хэлж, хэрэгжүүл
- Чадна, сурна, хийнэ бүтээнэ гэсэн хүсэл сэтгэлийг байнга давтан хэлж, хэрэгжүүл
- Сайн сайхан зүйлсийн тухай мөрөөдөн, түүндээ итгэ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МИНИЙ ӨНГӨЛӨН САЙЖРУУЛАХ ДАВУУ ТАЛУУД

Амьдрал бол аялал гэдэг үгэнд та итгэдэг үү? Энэ бол магадлалтай асуудал. Учир нь хүн амьдралдаа олон шилжилтүүдийг даван туулдаг ажээ. Цэцэрлэгээс сургууль, их дээд сургууль коллеж - сурагчаас оюутан, оюутны амьдралаас ажилтан гэх мэт шилжилтийн өөр ямар үе байхыг та дараалуулан бодож олоход хялбар. Иймд амьдрал- сургууль- хичээл-ажил- найз- хамт олон, орчин тойрны хүмүүст бид зорилго, итгэлтэйгээр өөдрөг хандах төв цэг нь таниас, өөрөөс чинь эхэлнэ.

Та өөрийнхөө сайн талууд, хүсэл сонирхол, авьяас, ур чадваруудаа нээн хөгжүүлж тэдгээрийг үнэт зүйлс болгох нь таны зорилго юм. Тэдгээр сайн талууд, өмнөө тавьсан зорилтоо мэдлэг, боловсролоор баяжуулан түүнийгээ зах зээлд өндөр үнээр борлуулах энэхүү тасралтгүй, зохион байгуулалттай сурах-ажиллахын хэлхээнээс хамт олон, айл гэр, албан байгууллага, нийгэм бүрддэг. Ийм учраас таныг оюутны ширээгээ орхин одох мөчөөс эсвэл магадгүй сэргэлэн, зорилготой охид, хөвгүүд бол оюутан байхаасаа эхлэн ажлын байр, хамт олны бүрдлийг бий болгосон байдаг. Дээр өгүүлсэн орчныг бүрдүүлэгч зүйлүүд байнгын хөгжил хувьсалд оршин байдаг учраас биднээс хөгжил, хурд, зорилгодоо хүрэх арга замуудаа олон хувилбараар төлөвлөн, итгэлтэйгээр урагшлахыг шаарддаг.

Сургуулиа төгсөж мэргэжил эзэмшсэнээр ажил хэмээх шинэ талбар руу та очино. Догдлох, түгших ч явдлууд тохиолдоно. Ажил олгогч хэмээх таны таньж мэдэхгүй ертөнц нь таньтай адил хүсэл сонирхол, хоббитой, ажил мэргэжил адил эсвэл өөр байж ч болох нэгэн. Та болон таны ажил олгогч, та хоёрыг нэгэн зорилго, хүсэл мөрөөдөл нэгтгэж байдаг. Харин

та өөрийнхөө сайн талуудыг товч тодорхой, эерэг сэтгэлгээ, итгэлтэйгээр ойлгуулж би таньд \жишээ нь соёлт харилцааны, эд зүйлстэй харилцах, бодол санааны, тоо тооллын\ ийм хүрээний ур чадварууд, мэдлэгийг илтгэн харуулж чадна. Ингэснээр ийм ийм төрлийн ажил хийж, \тоог бодитой хувиар илэрхийл\ хувиар ашиг, үр дүн нэмэгдэнэ, мөн би ингэж ажилласнаар энэ ажлын байр, албан байгууллага бизнесийн, харилцагч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж ингэж нэмэгдэнэ гэх мэтээр бодит тоо баримт судалгаан дээр тулгуурлан өөрийгөө чөлөөтэй нээж ойлгуул. Ингэснээр та өөрийгөө хөдөлмөрийн зах зээлд амжилттай борлуулж чадна.

Ажил олгогчид юунд анхаарлаа хандуулдаг вэ? Тэд энэ хүнд итгэл хүлээлгэвэл яаж ажиллаж бидний ажил хэрхэн үр дүнд хүргэх бол, үүрэг хариуцлагыг ухамсарлахдаа ямар бол гэх зэрэгт анхаарлаа хандуулж тэдгээр асуултынхаа хариуг өөрөөсөө хайдаг. Чухамдаа энэ зорилго, хүсэл мөрөөдөл, итгэл та хоёрыг нэг зүгт чиглүүлж байна. Хүний хүсэл мөрөөдөл, авьяас, ур чадварууд яагаад ажлын байранд чухал ач холбогдолтой вэ? Учир нь таны хүсэл сонирхол таныг ажилд хөтөлдөг. Та хүсэл сонирхлоороо ажлаа удирдан мөн ажил таныг тэрхүү хүсэл мөрөөдөл итгэл үнэмшил эрэл хайгуулд дагуулдаг ажээ.

За ингээд бид өөрт байгаа давуу тал, үнэт зүйлсээ дэлгэрүүлэн судалъя. Та бидэнд сайн сайхан төрх, бие бялдар, хүсэл сонирхол, авьяас, хөгжилтэй, ухаалаг зан төлөв бас найз, эцэг эх, багш нар бий. Эдний нэгээхэн чухал хэсэг нь таны хүсэл сонирхол, авьяас, мөн ур чадварууд юм.

Хүсэл сонирхол, авьяас, ур чадварын тухай

Ур чадвар энэ бол сургалтын үр дүнд хийж гүйцэтгэж чадах болсон үйлдэл юм. Жишээ нь ном унших, бичих нь таны сургуульд сурсан ур чадварууд бөгөөд хүнтэй харилцах, мод боловсруулах, оёдол эсгүүр хийх нь мөн л ур чадварууд билээ.

За одоо ур чадваруудаа яаж хэрэглэж буйг нэгтгэн үзье.

Үүнд:

◆ *Харилцааны ур чадвар*

Үе тэнгийнхэн ба томчуудтай ярилцахдаа өөртөө итгэлтэй байх, таны яриаг тэд хэрхэн хүлээн авч буйг мэдрэх, аливаа зүйлийн тухай ойлгомжтой, товч, тодорхой ярьж, бичиж, тайлбарлаж байх.

◆ *Техник, технологийн хэрэглээний ур чадвар*

Компьютер, хэвлэгч, утас, факсын аппарат, цахим шуудан, бусад багаж хэрэгсэл зэргийн хэрэглээ.

◆ *Багаар ажиллах,бусадтай хамтран ажиллах*

Хамтран ажиллаж буй хүмүүсийнхээ зан ааш харилцааны өнгө аясыг мэдэрч харилцаж байх, хүмүүсийн итгэлийг даадаг байх, аливаад хариуцлагатай ханддаг байх.

◆ *Асуудал шийдвэрлэх*

Асуудал, асуулт боловсруулан шийдэхдээ бусадтай хамтран ажиллаж зөв шийдэлд хүрэхэд манлайлж чадах эсэх

◆ *Тооцоотой байх*

Худалдаа хийх, тооцоо, төсөв зохиох эдгээр нь таны өдөр тутмын амьдралд байнга тохиолдон, таны ажил хөдөлмөр эрхлэхэд ч мөн хэрэглэгдэх тустай.

Ур чадвар нь мэдлэгийн дөрвөн талт хэмжүүрийн нэг юм. Иймд дараахь байдлаар илэрхийлнэ.

◆ Юуг мэдэх - энэ агуулгад баримт материалын тухай мэдлэгийг илэрхийлнэ

◆ Яагаад мэдэх - Энэ агуулгад байгал дэлхий, нийгэм, хүмүүст хэрэглэгдэх зарчмын тухай мэдлэгийг илэрхийлнэ

◆ Яаж, хэрхэн мэдэх - Ажлын байранд үүрэг хариуцлага хүлээх чадамж мөн ур чадваруудаа нэмэгдүүлэх тухай ойлголт. Иймд зорилго нь танин мэдэхүй хийгээд,

хөгжүүлэх тухай бус харин хийж гүйцэтгэх чадамжийг чухалчилсан байна.

- ◆ Хэн мэдэх – Нийгэм, өөр хүн ба шинжээчидтэй хамтран ажиллах

Сонирхол гэдэг нь таны хийх дуртай, бахархалтай ажил үйлс юм. Жишээ нь сагсан бөмбөг тоглох, ном унших, эд зүйлс бүтээж хийх гэх мэт.

Авьяас байгалиас заяана. Аливаа зүйлсэд түргэн, сайн хийж чадах хариу үйлдэл. Авьяас нь сургалт хичээл, хөдөлмөрийн үр дүнд хөгжинө. Жишээ нь зарим хүн байгалиас заяасан сайхан дуу хоолойтой, үүнийг хоолойн хөгжлийн дасгал сургуулиар хөгжүүлэн сайн дуучин болно. Гарын ур дүй сайн хүмүүс хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүнд мужаан болох жишээтэй.

Дасгал 1

Одоо өөрийн ур чадваруудаа үнэлцгээе. Энэхүү дасгал нь таны ур чадварууд, хийх дуртай ажлыг тодорхойлон, зорилго мөрөөдлийг ажил хөдөлмөртэй уялдуулах нэгэн алхам болох юм.

1- Муу 2- Багавтар бий 3- Дундаж 4- Сайн 5- Маш сайн

№	Ур чадварууд	Оноо
	Нийтлэг ур чадвар	
1	Хүмүүстэй хамт байх	
2	Сонсох	
3	Хүнийг ойлгож нөхөрлөх	
4	Бусдыг хүндэтгэх	
5	Хүмүүст туслах	
6	Бусдыг хүлээн зөвшөөрөх	
7	Бусадтай хамтран ажиллах	
8	Бусдад нийцэмжтэй байх	
9	Хошигнох	

Аман ба бичгийн харилцаа

- 1 Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх
- 2 Ойлгомжтой, цэгцтэй байх
- 3 Мэдээллийг бусдад танилцуулах, илтгэх
- 4 Тод, уран яруу ярих
- 5 Тайлбарлах, тодорхойлох
- 6 Гадаад хэлээр ярих

Манлайлах

- 1 Бусдыг урамшуулах, сэдэл тэмүүлэл бий болгох
- 2 Өөрөө үлгэр дууриал үзүүлэх
- 3 Дарга, удирдагчгүйгээр ажиллах
- 4 Шинэ санаа санаачлах
- 5 Яаралтай үед самбаачлах
- 6 Асуудлыг олж илрүүлэн, шийдвэрлэх
- 7 Шинэ нөхцөл байдалд дасах
- 8 Үүрэг, хариуцлага хүлээх

Бүтээн туурвих, зөн билэгийн

- 1 Гярхай ажигч
- 2 Шинийг санаачлах
- 3 Шүүмжлэх
- 4 Аливаа юмс үзэгдлийн учир шалтгааныг олох
- 5 Алсын хараа
- 6 Бүтээлчээр сэтгэх
- 7 Төсөөлөн бодох

Суралцах

- 1 Тэмдэглэх, ажиглах судлах
- 2 Нэгтгэн дүгнэх

№	Тоо, тооллын	Оноо
---	--------------	------

- | | | |
|---|-------------------------------|--|
| 3 | Цээжлэх | |
| 4 | Унших, бичих | |
| 5 | Асуулт дэвшүүлэн үнэлж дүгнэх | |

Тоолох, тооцоолох

- | | | |
|---|--|--|
| 1 | Статистик тоо баримт хэрэглэх | |
| 2 | Мөнгийг зөв зарцуулах | |
| 3 | Нягтлан тооцоолох, баримт бичиг хадгалах | |
| 4 | Төсөв зохиож, хэрэгжүүлэх | |
| 5 | Урьдчилан тооцоолж, дүгнэх | |
| 6 | Гарын ур дүй | |

Мужаан урлал

- 1 Багаж, хэрэгслэлийн хэрэглээ
- 2 Хоол хийх
- 3 Цэцэрлэгжүүлэх
- 4 Засах, сэлбэх
- 5 Нягт нямбай

Заавар, дүрэм журмыг сайн дагаж мөрдөх

- 1 Цагаа зөв хуваарилан баримтлах
- 2 Эцсийн хугацааг хүлээх
- 3 Мэдээллийг тэмдэглэх
- 4 Үүрэг даалгаврыг биелүүлэх
- 5 Ажлыг зохион байгуулах
- 6 Уншиж ойлгох
- 7 Өгөгдөл тоо мэдээлэл оруулах
- 8 Ачаалал дааж ажиллах
- 9 Тэмдэглэл хөтлөх
- 10 Урлаг уран сайхан

Дүрслэх туурвих

- 1 Дизайн, зохион бүтээх
- 2 Фото зураг авах
- 3 Уран сэтгэмж
- 4 Хөгжөөх
- 5 Зурах, дүрслэх, бодох
- 6 Зурах, дүрслэх, будах

Дээрх жагсаалтыг дахин харна уу. Онцгой дуртай, хийж гүйцэтгэх сонирхолтой ажлаа дугуйлан тэмдэглээрээ.

Та жагсаалтыг уншин тэмдэглэж дууссаны дараа 4 ба 5 гэсэн үнэлгээ өгсөн мөрүүдээ дахин дугуйлан тэмдэглэнэ. Учир нь таны давуу талуудыг илрүүлэх нь цаашид суралцах, ажиллахад тустай болно.

Та хийж гүйцэтгэх дуртай, илүү таашаадаг зүйлсээ тодорхойлж байх явцад та тэдгээр ур чадвар, туршлагаа хаана хэрхэн сурсан, хэрэглэж байсан тухайгаа санан, эргэцүүлэн бод. Эдгээр туршлага нь магадгүй таны хийж байсан ажил, ажлын байр, үйлдвэрлэл дээрх сургалтын явцад хуримтлагдсан бөгөөд эдгээр нь таныг суралцах, ажил хайх, мөн ярилцлагад орж байхад таны тухай сайн мэдээлэл өгөх маш сайн жишээ, түүх болох юм.

Дасгал 2

МИНИЙ ТУХАЙ

Товч, жагсаан бичнэ үү

Би ямар авьяас, ур чадвар, давуу чанартай вэ?

Миний сонирхол юу болох, юунд илүү идэвхитэй ханддаг, үнэт зүйл юу вэ?

Миний зорилго, мөрөөдөл буюу 1-2 жилийн дараа би юу сурч эзэмшсэн, эсвэл туршлага цуглуулсан, хаана ямар хөдөлмөр эрхлэх вэ?

Миний зан төлвийн сайн ба муу гурван чанар юу болох?

Ажлын нөхцөл (Миний хайж буй ажлын байр, орчин)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЖИЛ МЭРГЭЖИЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Мэргэжил гэж юу вэ?

Мэргэжил гэдэг нь тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг чадвар, дадлын цогц юм. Энэ нь нэг талаар хөдөлмөртэй холбоотой, нөгөө талаар боловсролтой холбоотой ойлголт юм. Таны амьдарч буй орчин, эцэг эх, нийгэм танаас ажил мэргэжил шаардаж байдаг. Учир нь нийгмийн хөгжил болон амьдралын хэрэглээ нь ажил хөдөлмөрийн үр шим дээр тогтож байдаг.

Аливаа ажлыг хийж гүйцэтгэхэд түүний өмнө хүлээх үүрэг, түүнийг хийж гүйцэтгэх үйлдэл зэрэг нь үйл ажиллагааг гүйцэтгэхэд заавал шаардлагатай зүйл юм. Тийм ч учраас ажил, хөдөлмөрийн хуваарь бий болж ажлынхаа онцлогоос хамааран тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд ямар мэдлэг, ур чадвар, дадал, мөн ямар мэргэжил шаардагддаг эсэхээр үүрэг, үйлдэл нь тодорхойлогддог юм.

Мэргэжил эзэмшинэ гэдэг нь тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэххэрэгцээнднийцүүлжзохионбайгуулалттай сургалт, хөтөлбөрийн үр дүнд эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн ба харилцааны соёлын төлөвшлийг хэлэх бөгөөд зөвшөөрөгдсөн ажлын байранд ажиллах эрхтэй болж буй үйл явц юм.

Нийгэм, эдийн засаг, улс төр, шинжлэх ухаан, технологийн хүрээний хөгжлөөс хамааран өнөөдөр АНУ-д 21 мянга гаруй мэргэжил бүртгэгдсэн бол ОХУ-д 7000 гаруй, Монгол Улсад 3000 гаруй мэргэжил байдаг байна.

Мэргэжил эзэмшсэн хүн тодорхой ажлын байранд очиж ажиллах эрх, үүрэгтэй болж байна гэсэн үг. Таны ажлын байран

дээр хийх ажил нь чухамдаа тухайн ажил мэргэжлийн онцлог, гүйцэтгэх үүрэг, ур чадваруудыг яруу тодоор илэрхийлэн, та юуны төлөө, ямар үр дүн гаргаж ажиллах мөн цаашид илүү сайжруулахын тулд та ямар үүрэг хариуцлага хүлээвэл зохистойг илтгэнэ. Мөн ажлын байранд тавигдах шаардлага гэдэг нь ур чадвар, чадамжуудыг хамрах бөгөөд тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд ажилтан эдгээр ур чадвар, чадамжуудыг заавал илэрхийлэн харуулах ёстой. Жишээ нь, өөрийн биеийн хөгжил ба харилцааны ур чадвар, зарим тохиолдолд ажлын байранд техник хэрэгсэл ашиглаж чаддаг байх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам зааврыг нягт баримтлах зэрэг шаардлагууд байдаг. Ажлын байранд тавигдах шаардлага нь нийтлэгээрээ тусгай сургалт мөн туршлагыг хийгээд түүнийгээ хэрэглэх, илэрхийлэхийг шаардана.

Хүүхэд, залуучууд мэргэжлээ хэрхэн сонгож буйг судлан энэ ажлын байр ямар ур чадвар шаардах, ямар үүргийг гүйцэтгэх, ажлын байран дээр илүү ихийг хэрхэн бүтээх, хөгжих тухай нарийвчлан судлахыг бид ажил мэргэжил мөн ажил мэргэжлээ төлөвлөх гэсэн ойлголтоор илэрхийлнэ. Та бүхэн хүмүүс карьер хөөх гэж нэрлээд байдгийг сонсож байсан болов уу.. Чухамдаа энэ үг ажил мэргэжил эзэмшин, ямар хүрээний ур чадварууд шаардах, ямар үүрэг гүйцэтгэхийг судлан тухайн мэргэжлийг эзэмшин, ахиж хөгжих буюу мэргэшихийг цогцоор нь илэрхийлнэ.

Ийнхүү бид хөдөлмөрийн ертөнцийн эд эс бүхэн рүү яваад орох нь энэ. Иймд бид дараах таван бүрэлдэхүүнийг мэдэх хэрэгтэй. Өндөр хөгжилтэй орны залуучууд, иргэд эдгээр мэдээлэл, зөвлөгөөг дараалалтай, цогцоор нь хүртдэг учраас тэд ажил мэргэжлийн зөв сонголт хийдэг ажээ.

- ◆ **Ажил мэргэжлийн мэдээлэл.** Үүнд суралцах, хөдөлмөр эрхлэлтээ хадгалах, төлөвлөлт хийхэд шаардлагатай мэдээлэл бөгөөд гүйцэтгэх үүрэг, боловсрол, сургалтын

боломжууд, мөн цалингийн тухай мэдээллийг агуулна. Мөн ажил мэргэжлийн ангилал, шаардах ур чадварууд, сургалтын байгууллагын мэдээлэл, тэдний хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, хөдөлмөрийн зах зээлийн төлөв хандлага, тухайн ажлын байрны онцлогын тухай иж бүрэн мэдээлэл юм. Иймд ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээний мэдээллийн үндсэн эх үүсвэр болно.

- ◆ **Ажил мэргэжлийн боловсрол.** Боловсролын байгууллагуудад эсвэл олон нийтийн байгууллагуудын багш, зөвлөхүүд түгээдэг, боловсролын ба мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад суралцагчийн орчин, гэр бүл, нийгэмдээ оруулах оюуны ба капиталын хөрөнгө оруулалтыг ойлгоход туслан тухайн суралцагчийн сэдэл тэмүүлэл, үнэт зүйлсийг нэмэгдүүлдэг. Үүгээр хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдлэг, сурч хөгжих, амьдрал, ажил хөдөлмөрийн сонголт хийх ур чадваруудыг олгон ажил хөдөлмөрийн төлөвлөлтийг өөрсдөө хийж гүйцэтгэх хэрэгслүүдтэй танилцуулна.
- ◆ **Ажил мэргэжлийн зөвлөгөө.** Хөдөлмөр эрхлэх ойрын зорилтууд, бусдаас өөрийн ялгарах онцлогийг танин мэдэж, өөрийн төлөвлөгөө боловсруулах, удирдан хэрэгжүүлэх, сургуулиас ажлын байр, цалинтай ажлын байрнаас буюу ажилтан байр сууринаас аж ахуй эрхлэх гэх мэт шилжилтийн үйл явцыг төлөвлөгөөтэй болон төлөвлөлтгүйгээр удирдан хөгжүүлэх ур чадвар олгодог.
- ◆ **Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө.** Залуучууд ойрын үед хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулан хөдөлмөр эрхлэх боломжуудаа зорилго, дэс дараалал бэлтгэлгүйгээр гүйцэтгэх, ажил хайх, хөдөлмөр эрхлэлтээ удирдахад суралцах, ур чадвараа дээшлүүлэх боломжуудыг олгодог.

- ◆ **Ажлын байрны зуучлал.** Ажлын байр, сул ажлын байрыг залуучуудад санал болгох, зуучлах үйл ажилгаа болно.

Ажил мэргэжлийн мэдээлэлтэй танилцана уу. Эдгээр жишээ нь зарим салбар, ажил мэргэжлийг хамарна. Та сонирхож буй, эрэлттэй ажил мэргэжлийн тухай мэдээллээ хөдөлмөрийн байгууллага, ажил мэргэжлийн зөвлөхүүдээс хүлээн авах боломжтой.



Ажил мэргэжлийн нэр:

ХООЛ, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЧ

Гүйцэтгэх үүрэг:

- ◆ Мал амьтан, холбогдох хүнсний зүйлсийг хүн ба амьтны хоол, тэжээлд зориулан бэлтгэх, боловсруулах, төрөл бүрийн талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн хийх, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон хүнсний зүйл боловсруулах, хадгалах, нөөцлөх, төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг амтлах, зэрэглэл тогтоох ажил эрхэлнэ
- ◆ Мах, загас болон хүнсний бусад бүтээгдэхүүнийг хадгалах, нөөцлөх, дахин боловсруулалт хийх
- ◆ Талх, бялуу, жигнэмэг зэрэг бусад төрлийн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ◆ Холих, хутгах, жигнэх, шарах машин, саванд хэмжиж тааруулсан орцыг найруулан хийх
- ◆ Стандарт болон чанарын шаардлага хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор түүхий эдийн чанарыг шалгах
- ◆ Жигнэх, шарах хугацааг тодорхойлох зорилгоор бүтээгдэхүүний гадаад байдлыг хянах, шарах шүүгээний халууны хэмийг хянах, тохируулах
- ◆ Хяналтын дээж авах, шаардлагатай үед бүтээгдэхүүний орчинг тохируулах зэргээр бүтээгдэхүүний чанарыг савлаж баглахаас өмнө шалгах, хянах
- ◆ Бэлэн бүтээгдэхүүн болон чихэр амттаныг хэв оруулах, чимэглэх, хатаах, давслах, шүүс тос гаргаж авах.



Боловсролын шаардлага, бэлтгэгдсэн байдал:

- ◆ Мэргэжил олгох сургалтыг төгсч мэргэжлийн үнэмлэхтэй байх
- ◆ Нийгэмд нэр хүндтэй аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж байсан туршлагатай байвал давуу тал болох

Ур чадварын шаардлага:

- ◆ Бүтээлч хандлага, харилцааг эрхэмлэдэг
- ◆ Орц, хэв маяг, сайн, сайхны давуу талуудыг мэдрэх мэдрэмж, хийх хүсэл эрмэлзэлтэй
- ◆ Гараар эд зүйлс хийх
- ◆ Ой тогтоолт сайн
- ◆ Эд материалын чанар, хэмжээс, нэгдэл, нийлэмжүүдийг сонирхон судалдаг мөн мэддэг байх
- ◆ Заавар журам, үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч даган биелүүлэх
- ◆ Багаар ажиллан бусдын санаа бодлыг хүндэтгэх

Хувийн зан чанарын шаардлага:

- ◆ Анхаарал төвлөрүүлдэг
- ◆ Хувийн зохион байгуулалт, харилцааны соёлтой
- ◆ Ажлыг зохион байгуулах арга барил эзэмшсэн
- ◆ Түргэн шуурхай хөдөлгөөнтэй
- ◆ Хичээнгүй
- ◆ Эрүүл чийрэг

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, баримтлах зарчим:

- ◆ Үйлдвэрлэл, технологийн горимыг биелүүлэх
- ◆ Үндсэн ба туслах материал, орц, бүтээгдэхүүнийг сонгох, зэхэх, оролт, гаралтыг мэддэг
- ◆ Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зөв сонгон суурилуулж, ажлын байрыг оновчтой зохион байгуулах
- ◆ Ажлын байранд физик, биологи, химийн бодис бүтээгдэхүүн, дуу шуугиан, хэсгийн доргион, цахилгаан соронзон орон, бичил цаг уур, гэрэлтүүлэгтэй зүй зохистой харилцаж ажиллах
- ◆ Ажлын байр, эрүүл ахуй орчны эмх цэгц, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах
- ◆ Хамгаалах хэрэглэлийг хэрэглэж хэвших
- ◆ Өөрийн хараа, булчингийн ачааллыг бууруулах, ядаргаанаас урьдчилан сэргийлэх

Ажил мэргэжлийн нэр:

ЦАХИЛГААНЧИН /УГСРАЛТЫН БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН/

Гүйцэтгэх үүрэг:

- ◆ Сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээний газар, орон сууц болон бусад барилга байгууламжийн цахилгааны шугам ба тоног төхөөрөмжийг суурилуулах, засвар үйлчилгээг нь хийх
- ◆ Театр болон радио телевизийн студид цахилгаан тоног төхөөрөмж суурилуулах, засвар үйлчилгээг хийх
- ◆ Цахилгаан машин механизм, хөдөлгүүр, үүсгэгч, хяналтын аппарат, багаж хэрэгсэл зэрэг төрөл бүрийн цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгаан шатны эд ангийг тохируулах, тааруулах, засах
- ◆ Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, нисэх ба усан онгоц, автомашины цахилгаан аппаратыг тохируулах, тааруулах, засах
- ◆ Үйлдвэрлэсэн цахилгаан барааг шалгах, турших
- ◆ Холбогдох бусад үүргийг гүйцэтгэх
- ◆ Бусад ажиллагчдад хяналт тавих



Боловсролын шаардлага /бэлтгэгдсэн байдал/:

- ◆ Мэргэжил олгох сургалтыг төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй байх
- ◆ Нийгэмд нэр хүндтэй аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж байсан туршлагатай байвал давуу тал болох

Ур чадварын шаардлага:

- ◆ Механик сэтгэлгээтэй, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажилладаг
- ◆ Аливаа эд зүйлс, хийцийн зүй тогтлыг мэдэх, судлах хүсэлтэй
- ◆ Төсөөлөн бодож, дүн шинжилгээ хийн бүтээлч байдлаар асуудал, эд материалд ханддаг
- ◆ Харилцаа холбоо тогтоох, бусадтай товч тодорхой харилцдаг
- ◆ Гараар эд зүйлс хийх, засах, сэлбэх
- ◆ Ой тогтоолт сайн
- ◆ Эд материалын чанар, хэмжээс, нэгдэл, нийлэмжүүдийг мэдэрч мэддэг

Хувийн зан чанарын шаардлага:

- ◆ Харилцааны соёлтой
- ◆ Хувийн зохион байгуулалт сайн
- ◆ Аливаад анхаарал хүлээцтэй ханддаг
- ◆ Эрүүл чийрэг
- ◆ Нягт нямбай гярхай
- ◆ Түргэн шуурхай хөдөлгөөнтэй байх

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд анхаарах зүйлс:

- ◆ Технологийн арга барил эзэмшсэн
- ◆ Механикжуулалт автоматжуулалт, алсын удирдлагын техник хэрэгслийг хэрэглэдэг
- ◆ Шугам сүлжээ угсрах, засвар үйлчилгээ хийх, зөөж тээвэрлэх, дангаар нь буюу технологийн системийн цогцолборын бүрэлдэхүүнд ашиглах үед аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх

- ◆ Ажлын байрны эмх цэгц зохион байгуулалтыг чанад сахиж ажиллах
- ◆ Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, төлөв байдал, шатах чанарын тухай өндөр мэдлэг, мэдээлэлтэй энэ хүрээний мэдлэг боловсрол, ур чадваруудаа байнга дээшлүүлж хөгжүүлэх
- ◆ Хэрэглэж буй хими, биологи, физикийн бодис бүтээгдэхүүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах арга журмыг баримтлах
- ◆ Гал гарах, тэсэрч дэлбэрэх аюулаас урьдчилан сэргийлэх
- ◆ Хаалт хамгаалах хэрэгсэл, дохиолол хэрэглэж хэвших
- ◆ Агаар дамжуулах хоолой, сэнс, агаар халаагч, агааржуулагч, сэнсний өрөө, шүүлтүүр, зөөлөн холбоо, доргио намсгагч, хавхлаг, агаар сорогч, агаарын хольц тунгаагч зэрэг тоног төхөөрөмжүүдийг зөв ажиллуулах
- ◆ Гал эсэргүүцэх техник, газардуулга зөв хийж, хэрэглэж сурах

Ажил мэргэжлийн нэр:

ХҮНД МЕХАНИЗМЫН ОПЕРАТОР

Гүйцэтгэх үүрэг:

- ◆ Өргөх, эргэх, зөөвөр механизм - төхөөргөөр газар шороо, чулуу болон бусад төрлийн материалыг бэлтгэх, ухах, зайлуулах, тараах, хүнд зүйлийг өргөх тусгай зориулалтын хөдөлгүүртэй машин механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, чиглүүлэх, ажиллуулах, хянах ажил эрхэлнэ
- ◆ Төхөөрөг-механизмыг ажиллуулахад бэлтгэх, суурилуулах
- ◆ Багаж, төхөөрөмжийн хурд, өндөр зэргийг тохируулах
- ◆ Хөдөлгөөнт төхөөрөг, машиныг жолоодох, ажиллуулах
- ◆ Мод гуалин, чулуу, шороо зэрэг хүнд зүйлс материалыг өгрөх, хураах, зайлуулах зорилгоор нэмэлт төхөөрөмж, багаж ажиллуулах
- ◆ Өргөх машин, хөдөлгөөнт болон суурин өргөгч цамхагийг барилгын тээвэрлэлтийн агуулахын үйл ажиллагаанд ашиглах, ажиллуулах, хянах
- ◆ Механик, гидравлик ажиллагаатай шанагаар тоноглогдсон газар шорооны ажлын машинаар шороо, хад, элс, хайрга бусад материалыг ухах, зайлуулах
- ◆ Замын, хучилт, хучилтийн үеийг нягтруулах, тэгшлэх ажлыг гүйцэтгэх



Боловсролын шаардлага:

- ◆ Мэргэжил олгох сургалтанд хамрагдаж, мэргэжлийн үнэмлэхтэй байх
- ◆ Нийгэмд нэр хүндтэй аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж туршлага хуримтлуулсан байвал давуу тал болох

Ур чадварын шаардлага:

- ◆ Механикжуулалт, автоматжуулалт, алсын удирдлагын техник хэрэгслийг хэрэглэдэг
- ◆ Техник сэтгэлгээ сайтай машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах тэдгээрийг жолоодох сонирхолтой
- ◆ Тооцоолох, нягтлах ур чадваруудаа хөгжүүлсэн
- ◆ Бусдын заавар, дүрэм журмыг нягт даган биелүүлдэг
- ◆ Аливаад жижиг сажиг гэлтгүй анхааран авч үздэг
- ◆ Үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрдөг
- ◆ Харилцаа, хамтын ажиллагааг чухалд тооцдог
- ◆ Алсын хараатай

Хувийн зан чанарын шаардлага:

- ◆ Хувийн зохион байгуулалт, харилцааны соёлтой
- ◆ Ажлыг зохион байгуулах арга барил эзэмшсэн
- ◆ Түргэн шуурхай хөдөлгөөнтэй ажилч хичээнгүй
- ◆ Асуудал аливаа үйлдэлд анхаарал болгоомжтой ханддаг
- ◆ Эрүүл чийрэг

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд анхаарах зүйлс:

- ◆ Өргөх, эргэх, хөдөлгөөний, зөөвөр механизмийн ажиллах зарчим, зохион байгуулалтын аюулгүй эд ангийг зөв сонгон ажиллуулах
- ◆ Машин, тоног төхөөрөмж бүр аюулгүй ажиллагааны болон ашиглалтын заавартай байх тэдгээр журам, горимыг байнга дагаж мөрдөх
- ◆ Зохих хамгаалалт, хаалтууд бүрэн хийгдсэн байх, тэдгээрийг шалгаж нягталж байх
- ◆ Машин, тоног төхөөрөмжийг хөдөлгөөнгүй суурилуулсан, газардуулга хийж байх
- ◆ Ачаа даац, салхины хамгаалалт зөөлөвч, төгсгөлийн тулгуур, тулгуур эд ангиудын мэдлэгтэй
- ◆ Хамгаалах самбар, хаалт дохионы хамгаалах хэрглэл зэргийг журам дүрмийн дагуу хийж гүйцэтгэх, шалгаж нягтлах
- ◆ Асаах, унтраах товчлуур өөрөө гэнэт ажиллаж эхлэхээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх
- ◆ Доргиог үүсгэгч үүсгүүрүүдийн тухай мэдлэгтэй
- ◆ Машин, тоног төхөөрөмжийг суурилуулахад хялбар байх
- ◆ Хийж байгаа зүйлээ байнга хянаж байх нөхцлийг бүрдүүлэн шаардлагатай бол тусгайлсан гэрэлтүүлэг ашиглах
- ◆ Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлсийн нөлөөллийг сааруулах
- ◆ Өөрийн хараа, мэдрэл, булчингийн ачааллыг бууруулах, ядаргаанаас урьдчилан сэргийлэх

Ажил мэргэжлийн нэр:

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ФЕРМЕР

Гүйцэтгэх үүрэг:

- ◆ Улс, бүс, орон нутгийн зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглан судлах
- ◆ Мал амьтны үүлдэр, угсааг сайжруулах, гарах ашиг шим, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тодорхойлох, төлөвлөх хэрэгжүүлэх
- ◆ Мал амьтан тэжээх, маллах, өсгөх, арчлах
- ◆ Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд зориулан бэлтгэх, боловсруулах, хадгалах
- ◆ Өвчлөлт гэмтэл, өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх
- ◆ Мал амьтны биеийн байдлыг хянах, үзэж шалгах, үржүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх, нөхөн үржихүйтэй холбоотой ажил явуулах
- ◆ Мал тэжээх, маллах өсгөх, арчлахтай холбоотой машин техник, барилга бүтээцүүдийг цэвэрлэх, тээвэрлэлтийг хийж гүйцэтгэх
- ◆ Үйл ажиллагаа, бэлчээр ашиглалтын болон гүйлгээний анхан шатны бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх



Боловсрол, туршлагын шаардлага:

- ◆ Мэргэжил олгох сургалтанд хамрагдаж мэргэжлийн үнэмлэхтэй байх
- ◆ Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж туршлага хуримтлуулсан байвал давуу тал болох

Ур чадварын шаардлага:

- ◆ Байгаль орчин, амьтан, хоол тэжээлийн харилцаа хамаарлын тухай сонирхон судалдаг
- ◆ Амьтан ургамалтай харилцдаг
- ◆ Ажиглах, суралцах дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэхдээ сайн
- ◆ Их энерги, өөдрөг сэтгэлгээтэй
- ◆ Бусдад мэдээлэх, ойлгуулж туслах, зааж сургах
- ◆ Бусдыг мэдрэх мэдрэмжтэй, урам өгдөг
- ◆ Урьдчилан тооцоолж, дүгнэдэг, тоо тооцоолох арга ухаантай
- ◆ Амьтан, ургамал, сүү, тэжээл, хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах мэдлэгтэй
- ◆ Бэлтгэсэн бүтээгдэхүүнээ хадгалах, зарим боловсруулалт хийх
- ◆ Ачлага, уналагийн ажил, хэрэглэлийг хэрэглэх
- ◆ Спорт, байгалийн аялал жуулчлалын зарим ажлыг гүйцэтгэх
- ◆ Алсын хараатай
- ◆ Үүрэг хариуцлагаа дээдэлдэг
- ◆ Харилцаа, хамтын ажиллагааг чухалд тооцдог

Хувийн зан чанарын шаардлага:

- ◆ Тэсвэр тэвчээртэй
- ◆ Харилцааны соёлтой байх
- ◆ Үүрэг хариуцлагаа дээдэлдэг
- ◆ Санаа бодолдоо үнэнч, зөн билэг, байгалиа дээдэлдэг
- ◆ Аливаад анхаарал, хүлээцтэй ханддаг
- ◆ Эрүүл чийрэг
- ◆ Нямбай гярхай байх
- ◆ Түргэн шуурхай хөдөлгөөнтэй байх

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд анхаарах зүйлс:

- ◆ Байгалийн хүчин зүйлс, эрсдэлийн менежментийг боловсруулан хэрэгжүүлэх
- ◆ Байгаль орчин бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах
- ◆ Хоол тэжээл, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх технологи горимыг судлан мөрдөх
- ◆ Аялал жуулчлал байгалийн ба орон нутгийн хөгжлийн асуудлыг ойлгож шинийг хөгжүүлэх арга зам судлах хэрэгтэй

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА МИНИЙ СОНГОЛТ

Хүн төрөлхтөн юуг эрхэмлээд байна вэ? Насанд хүрсэн залуучуудаас яагаад хувь хүний хөгжил болон ур чадварыг шаардаад байна вэ? Түүний гол учир шалгаан нь бүтээмжит хөдөлмөр юм.

Хөдөлмөр эрхлэлт гэдэг нь нийгмийн болон хувийн хэрэгцээг хангах цалин орлого олох зорилготой үйл ажиллагаа юм.

Хөдөлмөр эрхлэхийн давуу тал, үр дүн:

- ◆ Хувь хүний хөгжил, төлөвшлийг бий болгоно
- ◆ Мөнгө, орлого олох
- ◆ Нийгмийн даатгал болон бусад төрлийн даатгал, тэтгэмж, хөнгөлөлт эдлэх эрх үүснэ
- ◆ Гэр бүл, орчин, нийгэмдээ үнэт зүйлс бүтээх
- ◆ Өөрийгөө хүндлэх
- ◆ Хүчирхэг байх
- ◆ Мэдлэг, боловсрол, мэдээллийг шүтэх
- ◆ Ажил, амралтын цаг эдлэх
- ◆ Ажлын байранд, үйлдвэрлэл дээр сурч, ур чадваруудаа хөгжүүлэн мэргэших
- ◆ Бусдад танигдах, хамт олон найз нөхдийн хүрээ тэлэх
- ◆ Улс орны хөгжилд хувь нэмэр оруулах

Сонголт шийдвэр

Та өөрийн хүсэл сонирхол, авьяас, ур чадвартаа тохирсон ажил мэргэжил, салбар хүрээг одоо тодорхойлох боломжтой болсон. Учир нь та “Ажил мэргэжлийн мэдээлэл”-ийг уншин, та өөрт байгаа үнэт зүйлсээ тэрхүү ажлын байранд тохирох эсэхийг дүгнэсэн учир одоо та бэлтгэл, эрэл хайгуулын ажилд хүчтэй орно.

Ингэхэд та чухам ямар сонголт хийвээ? Суралцаж төгссөн учир цалинтай хөдөлмөр эрхлэх мөн хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр ХӨДӨЛМӨРИЙН ТАЛБАРТ ГАРАХАД ТАНД ЯМАР АСУУДАЛ БАЙНА? Ажилтан болох буюу цалинтай ажил хийх эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэх гэсэн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн хоёр хэлбэр байдаг. Эдгээрийн ялгаа нь та аливаа байгууллагын ажилтан болвол таны цалин, орлого тухайн байгууллагын ашиг орлого, бизнесийн онцлогоос хамаарна. Харин та бизнес эрхэлбэл ашиг орлого мөн эрсдлээ өөрөө хариуцна. Ингээд таныг дээрх хоёр хэлбэртэй дэлгэрэнгүй танилцуулья.

Замнал 1

Цалинтай ажил хөдөлмөр эрхлэх бол

Та өөрийн бичиг баримтууд, таныг тодорхойлон илэрхийлэх баримт сэлтийг цуглуулан дараа нь очиж болох газруудыг жагсаан бичиж өөрийгөө сайтар магтахад бэлтгэ. Ингэхэд та, ажил олгогч, байгууллагад өөрийгөө амжилттай борлуулахын өмнө та өөрийн тухай, хөдөлмөр эрхлэлтийн түүхийг эдгээр агуулгаар бэлтгэнэ.

- ◆ Хүсэж буй ажлын байрны нэр.
- ◆ Онцлог ба хүсэл сонирхол.
- ◆ Та тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн тухай мэдээллийг хаанаас хэрхэн олж авсан, танд төрсөн анхны сэтгэгдэл.

- ◆ Хөдөлмөр эрхлэлтийн он дараалал, хамгийн сүүлд эрхэлж байсан ажлын байрны нэрээс эхлэн дэс дараалуулан бичнэ.
- ◆ Таны зан төлөв, ур чадвар, боловсролыг илтгэн тодорхойлох бичиг баримт, байгууллага, хүн.
- ◆ Сургуулиа саяхан төгссөн залуухан мэргэжилтэн танаас ажил олгогч асуух нийтлэг асуулт? ... таны ажлын туршлага. Та анх удаа ажил хайж байгаа бол цалинтай ба цалингүй мөн үйлдвэрлэл дээрх сургалт, бусад сайн дурын ажил, өрхийн үйлдвэрлэлд тусалж байсан тухайгаа өөдрөг, итгэлтэйгээр тайлбарлан ажлын туршлагаа дурдана.
- ◆ Таны давуу талууд

Ажил хайн, ажилд орно гэдэг нь: Судлах үйл ажиллагаа юм. Учир нь та орохоор зорьж буй ажлын байр болон тухайн аж ахуйн нэгж байгууллага, компани, салбар, онцлогийн талаар мэдэж болох бүхнийг мэддэг байх хэрэгтэй.

ЯАГААД?

Та чухам ямар нөхцөлд ажиллах хүсэлтэй байгаагаа бичиж байснаа санаж байна уу? Энэ нь яагаад заавал судлах ёстой вэ? Гэсэн асуултад хариулах эхний нөхцөл юм. Хайж буй нөхцөл боломжийг танд тухайн аж ахуйн нэгж байгууллага, компани олгох бололцоотой эсэхийг мэдэх хэрэгтэй шүү дээ. Нөгөө талаар, та тухайн компани, аж ахуйн нэгж байгууллага, тэнд ажиллахад чухам ямар шаардлага тавигддаг, тэд чухам юу хийдэг, тэнд ажиллагсдын талаар мэдэх хүсэлтэй байгаа нь тэдэнд ч мөн таатай санагдана.

ЮУГ СУДЛАХ ВЭ?

Хөдөлмөрийн зах зээлийн хандлага: Тухайн ажил, ажлын байрны эрэлт, мөн таны ур чадвар, туршлага, боловсрол шаардлага хангаж байна уу?

Тухайн салбар, үйлдвэрлэл: Таны сонирхож буй ажлын байр тухайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн одоогийн бодит байдал, мөн тухайн байгууллага, компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ юу болох?

Компани, аж ахуйн нэгж байгууллага: Таны зүгээс хайж буй нөхцөл, болзолтой таарч байна уу? Адил ойролцоо тал байна уу?

Ажлын байр, албан тушаал: Ямар албан тушаал вэ? Тавигдах шаардлага юу вэ? Та тэрхүү шаардлагыг хангаж байна уу? Тэрхүү шаардлага танд нийцэж байна уу?

Та: Хайж байсан нөхцөл, болзлыг тань хангаж байгаа бол таны зүгээс тэрхүү ажлын байранд очих бусдад алдахгүй байхын тулд өөр ямар чадвар, туршлага шаардлагатай байна вэ? Мөн та тэдэнд ямар давуу талуудыг илтгэн харуулах вэ?

ХААНААС СУДЛАХ ВЭ?

- ◆ Төрийн байгууллагын цахим хуудас
- ◆ Аж ахуйн нэгж байгууллага, компанийн цахим хуудсанд зочлон менежмент, санхүү, бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээ, зохион байгуулдаг арга хэмжээ, бусад байгууллагатай хамтран ажилладаг байдалтай уншин танилцах
- ◆ Сонин, сэтгүүл, нийтлэл, бусад хэвлэмэл материал
- ◆ Ажлын зар харж болох бусад эх сурвалж-ажил олгогчийн зүгээс ямар ажлын байр, ур чадваруудыг шаардаж байна вэ?
- ◆ Зурагт, радио
- ◆ Таны өөрийн танил, хамаатан, ах дүүгийн гэх мэт сүлжээ

Хамгийн чухал нь, хайж буй ажил, сонгосон мэргэжилтэйгээ холбоотой аливаа мэдээлэл, үйл явдалд байнга анхаарал хандуулан, чих тавьж байх хэрэгтэй. Энгийнээр хэлбэл эргэн тойрноо байнга **АЖИГЛА, СУДАЛ**

Танд байвал зохих

Үнэт зүйлс

- Ёс суртахууны хэм хэмжээ
 - Бусдад танигдах
 - Мөнгө олох
 - Нийгэмд хувь нэмрээ оруулах
 - Шударга ёсыг баримтлах
 - Өөрийгөө хүндлэх
 - Хүчирхэг байх
 - Мэдлэгтэй байх
 - Өөрийн гэсэн үнэ цэнэтэй байх
- Чөлөөт цаг, завтай байх

ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ БЭЛТГЭХ

ТАНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга нь 50-60 үгтэй, товч байх ба дараах мэдээллийг агуулсан байвал зохино. Үүнд:

- ◆ Хэн болох
- ◆ Боловсрол, сургалтад хамрагдан суралцаж төгссөн түүх
- ◆ Ажлын туршлага (хэрвээ ажилласан бол)
- ◆ Ажиллаж байсан салбар
- ◆ 3 гол ур чадвар
- ◆ Зан төлвийн тухай, эерэг ба зарим нэг засч болох сул талууд

Товч танилцуулгын зорилго

Ажил олгогчид таны тухай товч мэдээллийг өгөх, та чухам юу хийж чадах, ажил олгогчид таны талаар илүү ихийг мэдэх сэдэл төрүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, таныг ярилцлагад урих сэдлийг өгөх учиртай бөгөөд таны өргөдөл, намтрыг үргэлжлүүлэн унших уу, эсвэл тэд яах бол ...? хогийн сав руу ...? гэдгийг шийдэхэд нөлөөлөх учиртай.

Жишээ

Үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байсан, компьютерийн тоног төхөөрөмж суурилуулах, засварлахад чадварлаг.

Хичээнгүй, идэвхитэй, хүнтэй ая эвээ олдог, харилцааны соёлтой, компьютерийн техникч

Ямар ч үндэсний хоолыг маш сайн хийдэг, ялангуяа Солонгос үндэсний хоолыг сайн хийнэ, ажилсаг, сүлжээ ресторануудад ажиллаж байсан, эерэг сэтгэлгээтэй, итгэл даадаг, найдаж болох тогооч

Сургалтын байгууллагад ажиллаж байсан туршлагатай, манлайлагч, асуудал шийдвэрлэх, төлөвлөх, багаар ажиллах, хуримтлал үүсгэх, мөнгө төвлөрүүлэхэд онцгой авьяастай. Аливаа асуудлыг олон талаас нь үр дүнтэй шийдэхийг хичээдэг, ажлын ачаалал сайн даана, ажлыг цаг тухайд нь хийж гүйцэтгэдэг.

Ажил олгогч Таны талаар илүү ихийг мэдэх сонирхол төрснөөр таныг ярилцлагад урих учраас товч намтарт өөрийн талаар бүхнийг дурдах хэрэггүй юм. Учир нь, Та ярилцлаганд орохдоо өөрийн тухай дэлгэрэнгүй танилцуулах боломжтой.

Сургууль шинээр төгсөгчид Та бүхний хувьд, сурах явцдаа гаргасан амжилт, гавьяа шагналыг дурдах хэрэгтэй. Ажилтай холбоотой амжилт гаргаж байгаагүй гэж санаа зовох хэрэггүй бөгөөд таны аливаад хариуцлагатай, итгэлтэй, хэнтэй ч хамтран ажиллах эв дүйтэй, сонирхол авьяасыг тань илтгэсэн сургуулийн амжилт шагналаас дурдахаа мартуузай.

НАМТАР ЗАГВАР

/загвар/

Нэр

Хаяг

Холбоо барих утас (суурин болон гар утас)

Цахим шуудангийн хаяг

Товч танилцуулга

Ажлын туршлага

- ◆ Компанийн нэр болон ажилласан жил
- ◆ Товчхон, 1 мөр, компанийн танилцуулга
- ◆ Ажлын байр албан тушаалын нэр
- ◆ Тухайн ажлын байранд хамаарах үүрэг, хариуцлагын талаарх товч мэдээлэл
- ◆ Гавьяа шагнал, урамшуулал

Боловсрол

Хувийн мэдээлэл (*төрсөн он сар өдөр, хүйс*)

АЖИЛ ХАЙХ ҮНДСЭН ХОЁР ЗАМ БАЙДАГ.

1. Зарлагдсан ажлын байр:

- ◆ Зар (сонин, сэтгүүл гэх мэт)
- ◆ Ажилд зуучлах алба, агентлагууд
- ◆ Төрийн болон төрийн бус байгууллагууд, сургуульд зуучлан оруулдаг байгууллагууд хүлээн авсан ажлын сул байрны мэдээлэл
- ◆ Цахим ертөнц (ажил хайх цахим хуудас, ажилтан авч буй компанийн цахим хуудас гэх мэт)
- ◆ Хөдөлмөрийн өдөрлөг, яармаг
- ◆ Дэлгүүр, олон нийтийн газарт байрлуулсан зар, сурталчилгааны хуудсууд
- ◆ Зурагт, радио

ЗАР

- ◆ Хэвлэмэл материал (сонин сэтгүүл гэх мэт) нь байгууллага аж ахуйн нэгж, компаниудаар түгээмэл ашиглагдаж байгаа
- ◆ Мэдээллийн хамгийн нийтлэг хэрэгсэл
- ◆ Гарт ойр, хаанаас хэзээ ч авах, худалдаж авах боломжтой

2. Зарлагдаагүй сул ажлын байр:

Үүнийг та олохын тулд өөрийн, найз нөхөд, эцэг эх, хамаатны холбоо харилцааг ашиглан та тухайн ажлын байранд хандана.

ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ

Давуу талууд:

- ◆ Нийтлэг, нэг газраас олон талын мэдээллийг авах боломжтой
- ◆ Байгууллага, компанийн талаарх мэдээлэл болон ажлын байранд нь шаардагдах ур чадварын талаар дэлгэрэнгүй мэдэх боломжтой
- ◆ Ажлын байр санал болгож буй аж ахуйн нэгж байгууллага, компани болон ажил хайж буй иргэнийг холбож өгдөг ач холбогдолтой

АЖИЛД ЗУУЧЛАХ АГЕНТУУД

- ◆ Ажилд зуучлах байгууллагууд нь ажилд анх удаа орж буй, дунд эсвэл шилдэг топ менежер, гэрээт ажилтныг зуучлах зэрэг үйл ажиллагааны өөр өөр шат, түвшинтэй байдаг.
- ◆ Нээлттэй, сул байгаа ажлын байрны захиалгатай танилцах боломжоор хангадаг.

- ◆ Ажлын байранд ажилтныг аль болох зуучлан оруулах сонирхолтой байдаг. Учир нь тодорхой хувийн төлбөр авдаг.

ИНТЕРНЕТ буюу цахимт ертөнц

- ◆ Тухайн байгууллага, компаниуд, тэдний онцлог мэдээлэл
- ◆ Хүссэн ажлаа хайж олох олон талын зөвлөгөө (холбогдолтой материал, тэмдэглэл, шууд харилцах цахим хуудас гэх мэт)
- ◆ Тодорхой салбар дахь ажлын байрны мэдээлэл бүхий цахим шуудан, сонин, булангууд байна.

ТӨРИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГА ТЭДНИЙ ХАЯГ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

<http://www.mswl.gov.mn/>

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар

<http://www.hh.gov.mn>

Нийслэлийн хөдөлмөрийн газар <http://www.ubbirj.ub.gov.mn/>

Баянзүрх дүүргийн Хөдөлмөр халамжийн
үйлчилгээний хэлтэс-

<http://bzd.ub.gov.mn/>

Баянгол дүүргийн Хөдөлмөр халамжийн
үйлчилгээний хэлтэс-

<http://bgd.ub.gov.mn/>

Хөдөлмөрийн төв бирж

<http://www.labor.net.mn>

Бусад дүүрэг аймгуудад орших Хөдөлмөр халамжийн
үйлчилгээний хэлтэст хандах боломжтой.

Нийслэлийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар

<http://www.lsdw.mn/>

Ажлын байрны зар болон бусад холбогдох мэдээллийг дараахь цахим хаягуудад зочлон авна.

<http://lavlav.mn/>

<http://ejob.mn/>

<http://bjobs.mn/>

<http://ajildavna.mn/>

<http://news.mn/>

Түүнчлэн томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын цахим хаягаар орж, тэд ажилд авахдаа ямар шаардлага тавьдаг тухай ерөнхий ойлголттой болох боломжтой.

Замнал 2

Та ашиг орлого, эрсдлээ өөрөө хүлээн ажлын байр бий болгож Монгол улсын хөгжилд хувь нэмэр оруулах, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй бол:

- ◆ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл бизнесээ хөгжүүл” сургалтыг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос зохион байгуулдаг.
- ◆ Бизнесийн төслийн үр ашиг, эрсдлийн үнэлгээг нарийвчлан боловсруулдаг төсөл хэрхэн боловсруулах сургалтуудад суралцаж төгсөх нь чухал.

Гэвч танд бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгарах онцлог олон давуу тал, үр ашиг бүхий бизнес эрхлэх санаа байх хэрэгтэй бөгөөд чухам ямар зорилготой, юу хийх гэж байгаагаа тодорхой мэддэг, өөрийн санаа, боловсруулсан төслөө дэмжигч байгууллага, хүнд тайлбарлан ойлгуулж үр ашигтайг нь нотлох техник, эдийн засгийн үндэслэл байвал хөрөнгө санхүүжилт олдох магадлал тун өндөр. Энэхүү таны төсөл нь та ажлын байр шинээр бий болгож, нийгмийн баялгийг бүтээж түүнээ цалин хөлс, нийгмийн хангамжийн хэлбэрээр хуваарилан шинэ техник, технологи нэвтрүүлэх улмаар эдийн засаг, нийгмийн дэвшилд хүргэдэг билээ.

Бичил ба жижиг дунд үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахад дор дурдсан таван хүчин зүйлийг шаардана.

- ◆ Тоног төхөөрөмж, түүхий эд материалын
- ◆ Борлуулалтын
- ◆ Хүн хүчний
- ◆ Санхүүгийн
- ◆ Зохион байгуулалтын хүчин зүйлс байна.

Эдгээр хүчин зүйлс нь бизнесийн таван чиг үүрэгтэй холбоотой.

- ◆ Үйлдвэрлэлийн
- ◆ Борлуулалтын
- ◆ Боловсон хүчний буюу хүний нөөцийн
- ◆ Санхүүгийн
- ◆ Захиргааны гэсэн чиг үүргүүд байна.

Эдгээр чиг үүргийг бизнесийн зургаа дахь үүрэг болох менежментийн үүрэг нэгтгэн зангидна. Эдгээр үйлдвэрлэл, үйлчилгээг та удирдах үүргээ гүйцэтгэхийн тулд бизнес эрхлэгч та дараах гурван чадамжтай байх хэрэгтэй.

- ◆ Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чадамж
- ◆ Бүтээгдэхүүн худалдаж авах ба худалдах үүргийн чадамж
- ◆ Өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжил, орчинд дүн шинжилгээ хийх, зохицуулах, хяналт тавих, удирдах ба шийдвэр гаргах удирдлагын чадамж, манлайлах ур чадвар билээ.

Дараах сан, байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч болно.

- ◆ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- ◆ Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
- ◆ Тариалан эрхлэлтийг дэмжих сан
- ◆ Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл
- ◆ Банк, банк бус санхүүгийн байгууллагууд
- ◆ Хувийн хөрөнгө оруулалт
- ◆ Бусад эх үүсвэр

ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ, ҮҮРЭГ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ


Хөдөлмөрийн харилцаанд оролцогчид хөдөлмөрийн гэрээ байгуулснаар эрх үүрэг нь үүснэ. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажилтан ямар ажил үүрэг гүйцэтгэх, энэхүү ажил үүргийг хэрхэн биелүүлбэл ямар хэмжээний цалин мөн ямар нөхцлөөр ажиллах цалин хөлс, урамшуулал эдгээрийг бүхэлд нь ажил олгогчтой байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.

Шигтгээ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

Энэ нь гэрээний хоёр тал, ажил олгогч, ажилтан хоёрын харилцан хүлээх эрх, үүргүүдийг тодорхойлогч нөхцөлүүд юм.

Хөдөлмөрийн гэрээний агуулга



Мөн ажлын байранд тавигдах шаардлагад ур чадвар, мэдлэг боловсрол, өрсөлдөх чадамжуудаас гадна баримтлах ёс зүй, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн байнга баримтлах шаардлага, горим байна. Эдгээрийн зорилго нь таны аюулгүй, бүтээмжит хөдөлмөр эрхлэх нөхцлийг хангах юм. Ялангуяа уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим журмыг сайтар мөрдөх учиртай. Бусад салбар ажил үйлчилгээний хувьд ёс зүйн дүрэм, баримтлах зарчим, харилцааны болон манлайлал, гадаад хэлний гэх мэт ур чадварыг мөн илтгэн харуулах ёстой.

Цалин хөлс, урамшуулал

Ажлын байранд тавигдах шаардлага хангасан хүнийг сонгон хөдөлмөрийн гэрээ хийн гарын үсэг зурснаар хөдөлмөрийн харилцаа эхлэн ажилтан цалин, орлого олох боломж бүрдэнэ. Ажил олгогчоос ажлын цагт ажил хийж гүйцэтгэх гэрээний дагуу өдрөөр, цагаар, эсвэл хийсэн бүтээлийн хэмжээгээр үнэлэн тодорхой хэмжээтэй цалин хөлсийг зарим тохиолдолд урамшуулал, нэмэлт хөнгөлөлтийн хамт төлнө.

Зарим ажилтнууд, ажилласан долоо хоногийн хэмжээгээр хийсэн бүтээл, бүтээмжийг үл харгалзан цалин авч байдаг. Жишээ нь дэлгүүрийн худалдагчид ажилласан хугацаагаар цалингаа авна, гэвч зарим дэлгүүрүүд худалдсан барааны тоо хэмжээ, орлогыг харгалзана.

Ихэнх ажилтнууд цалингаа долоо хоногоор, сараар тооцон цалинг банкны данс, эсвэл бэлэн мөнгөөр олгож байдаг. Мөн цалингаас суутган авдаг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын, хувь хүний орлогын албан татвар зэрэг татвар, суутгалууд байдаг бөгөөд эдгээрийг төр засгаас тодорхой бодлогын дагуу хураан төвлөрүүлж дараа нь таныг магадгүй өвдөх, тэтгэвэр, ажилгүйдлийн гэх мэт тэтгэмж авахад танд тодорхой тодорхой хувиар олгоно.

Ажлын урамшуулал, хангамжууд

Цалин, хөлсөөс гадна зарим ажлын байранд ажилласнаар төрөл бүрийн урамшуулал эдлэх эрхтэй. Эдгээр нь байгууллага аж ахуйн нэгжээс шалтгаалан төрөл, хэмжээний хувьд харилцан адилгүй. Урамшуулал олгох хэлбэр төрөл олон янз. Амралтын хоног нэмэгдүүлэх, богиносгосон цагаар ажиллуулах, хөнгөлөлт, мөнгөн урамшуулал олгох гэх мэт.

Ингээд та бүхэн энэхүү гарын авлагаас өөрийгөө танин мэдэхээс эхлээд өөрийгөө тодорхойлох мөн хөдөлмөр эрхлэлт хийгээд хөдөлмөрийн зах зээлд өөрийгөө хэрхэн борлуулах талаар их дэлгэрэнгүй биш ч гэсэн тодорхой хэмжээний мэдээлэл олж авсан гэдэгт итгэж байна. Энэхүү гарын авлагатай танилцсан таны амьдрал бүтээмжит, сонирхолтой хөдөлмөрөөр дүүрэн байхыг хүсэн ерөөж байна.



ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ
